



**Нөөц бэлчээр бий болгох**  
**Дундговь аймаг-Хулд сум**

Дундговь аймгийн Хулд сум нь цөлөрхөг хээрийн бүсэд орших бөгөөд жилд 100-150 мм тунадас унаж, заримдаа 100 мм-ээс доошилж, хүчтэй шороон шуурганы давтагдал хавар 60 хувьд хүрэх нь бий. Манай орны малчид олон зуун жил өргөн уудам нутагт мал сүргээ бэлчээж нүүдлийн мал аж ахуй эрхэлсээр ирсэн. Малчид жилийн дөрвөн улиралд хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөндөө ээлжлэн бууж, ургац муутай жил /гантай/ малаа оторлон өөр соргог бэлчээр нутагт нүүдэллэн амьдарч ирсэн. Гэвч сүүлийн жилүүдэд суурин мал аж ахуйн хэлбэрт шилжсэнээр нэг газар мал сүрэг удаан бэлчээрлэж, нутгийн тодорхой нэг айлын ойролцоох газар, худаг уст цэгийн орчимд толбо, цэгэн байдлаар талхлагдалд илүү ихээр орж байгаа юм. Улмаар уур амьсгал, дулаарлын нөлөөгөөр ургамлын гарц муудаж, мал сүргээ услах булаг, шанд, гол, горхи ховордож байгаа нь хамгийн ихээр санаа зовоох асуудал болсон байна. Сүүлийн жилүүдийн судалгаанаас үзэхэд манай улсын малын тоо 44 хувиар өсч, мал бэлчээрлэх талбай 20 хувиар багасч, бэлчээрийн гарц 19-44 хувиар буурчээ. Судлаачид гандуу бүс нутгийн 76 хувь нь цөлжилт сул, 20 хувь нь дунд зэрэг, 3 хувь нь хүчтэй, 1 хувь нь нэн хүчтэй илэрсэн нутагт хамрагдаж байгааг тогтоожээ. Ийм цаг үед жирийн нэгэн малчин айл бэлчээрийг менежменттэй ашиглан байгалын эрсдэлээс мал сүргээ хамгаалах арга ухааныг санаачлан амьдралдаа нэвтрүүлж байгаа нь бусад малчин өрхүүдэд үлгэр дуурайл болж байгаа юм. Төр засгийн зүгээс малчин өрхүүдэд бэлчээр нутгийг ашиглах, хашиж хамгаалах, худаг гаргах, ус ашиглах эрхийг нээлттэй байхаар бодлогын хүрээнд тусгаж өгсөн нь нөөц бэлчээр бий болгон бэлчээрийг сэлгээтэй ашиглах боломжийг бүрдүүлж байгаа юм.

**Зүүн зургийн тайлбар:**

*Нөөц бэлчээрийн ерөнхий төрх*

**Баруун зургийн тайлбар:**

*Үндсэн ургамал сэргээн ургасан байдал*



**Байршил:** Дундговь аймаг, Хулд сум, 2-р баг

**Газар ашиглалтын төрөл:**

Бэлчээрийн мал аж ахуй

**Уур амьсгал:** Хуурай

**MONCAT мэдээллийн сангийн нэр зүй:** QA MON-9

**Холбогдох технологи:** QT MON – 2,

**Арга барилыг нэвтрүүлсэн хувь хүн, байгууллага:**

Т.Төмөрчулуун, “Олдохын дэвжих” хоршоо

**Утас:** 99946288, 98259826

**Мэдээллийг цуглуулсан**

**хүн/байгууллага:** Л.Мөнхнасан, Ц.Ганчөдөр- Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв.

**Он, сар, өдөр:** 2009 оны 06 сарын 12

**Эмхэтгэгчийн тайлбар:** Тус сумын нутаг нь бэлчээрийн даац багатай, усны хангамж хангалтгүй, хуурай уур амьсгалтай, хөрс нь элсэрхэг, цөлжилтөнд нэрвэгдэж байгаа нутаг юм. Бэлчээрийн улирлын онцлогоос хамааран заагтай нүүдэллэн ашиглаж буйн зэрэгцээ мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд байгалийн нөлөө эрсдэл ихтэй байдаг.

## Асуудал, зорилго, бэрхшээл

### Тулгарч буй асуудал

- Цаг агаарын дулаарал
- Цөлжих үйл явц
- Усны хомсдол
- Бэлчээрийн ургамлын хомсдол
- Элсний нүүдэл
- Шороон шуурга

### Зорилго

Малын тоо толгой өсөж, уст цэгийн тоо цөөрч байгаагаас бэлчээрийн талхлагдал ихсэж буй өнөө үед бэлчээрийн мал аж ахуйгаас эрчимжсэн мал аж ахуйд шилжих замаар бэлчээрийн суурьшмал хэлбэрт шилжих оновчтой шийдлийг бий болгох зорилготой.

### Шийдвэрлэхэд чиглэгдсэн асуудал


Үндсэн	Товч тодорхойлолт	Шийдвэрлэх арга зам
Малчин өрхүүдэд арга барилын ач холбогдлыг сурталчлах	Малчин өрхүүд нөөц бэлчээр бий болгосноор олон км газар нутаг сэлгэн нүүдэллэж ойролцоох нутгуудын бэлчээрийг доройтуулах шаардлагагүй болно.	Төр засаг болон аймаг сумын урдирдлагын зүгээс бодлогын хүрээнд дэмжиж ажиллах. Арга барилын ашигтай талыг олон нийтэд сургалт сурталчилгаа явуулах замаар таниулах. Хашаа, худаг барихад хөрөнгө санхүүгээр дэмжлэг үзүүлэх.

## Оролцоо, шийдвэр гаргах

### Нийгмийн бүлэг



Мал аж ахуй эрхлэгчид



Багш, сургагч нар



Шийдвэр гаргагчид


### Арга барилд шаардагдах зардал

“Олдохын дэвжих” хоршоо	70%
Бусад	эх үүсвэрээс 30%
Нийт	100%

**Технологи сонголтод шийдвэр гаргагчид:** Нүүдлийн мал аж ахуй эрхлэгч малчин өрхүүд, фермерүүд

**Технологийг хэрэгжүүлэхэд шийдвэр гаргагчид:** Төр захиргааны удирдлагууд /Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Засаг даргын тамгын газар, сумын Засаг даргын тамгын газар/

**Оролцооны зарчмыг бүрдүүлэгчид:** “Олдохын дэвжих” хоршооны 10 айлын 18 гишүүн



Арга барилын зохион байгуулалтын схем зураг

1. **Байгаль орчны яам:** Яамнаас баримталж байгаа бодлого чиглэл нь тухайн арга барилыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй
2. **Аймгийн засаг даргын тамгын газар:** Иргэдийн хурлаас дэмжих бодлого баримталдаг
3. **Сумын засаг даргын тамгын газар:** Газрын зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлдэг
4. **Одохын дэвжих хоршоо:** Малчин өрхийн төлөөлөл хууль ёсны байгууллага
5. **Хоршооны гишүүд:** Үйл ажиллагаанд идэвхитэй оролцож ашиг, үр шимийг хүртдэг

#### Мэдлэг түгэээн дэлгэрүүлэх

*Сургалт:* 1999 оноос “Говийн санаачлага” төслийн хүрээнд сургалтанд хамрагдаж хоршоо байгуулж хамтран ажиллах эхлэл суурийг тавьсан. Орон нутгийн малчин иргэд, аймаг, сумын удирдлага ирж газар дээр нь туршлага судласан.

*Түгэээн дэлгэрүүлэлт:* Хулд сумын 3 малчин иргэн бэлчээр хашиж нөөц бэлчээртэй болж байгаа.

*Судалгаа:* Тодорхой бус.

*Орон нутгийн дэмжлэг:* Орон нутгийн удирдлагын зүгээс дэмжиж ажилладаг.

#### Урамшуулал

*Ажиллах хүч:* Олдохын дэвжих хоршооны нийт гишүүд арга барилын үр шимээр амжиргааны түвшин нь сайжирч байгаа.

*Хөрөнгө оруулалт:* “Мерси кор ТАН” төслийн дэмжлэгтэйгээр 2003 оноос хашсан бэлчээрээ томсгон 32 га болгож, 3000 ширхэг мод, сөөг тарьсан. Мөн талбайдаа гүн өрмийн худаг гарган усалтын систем, ус нөөцлөх сав байгуулж говийн хөдөөг ойжуулах, тэжээлийн олон наст ургамал тарих эхлэл суурийг тавьсан.

*Зээл олголт:* Зээл олгогдоогүй

*Орон нутгийн байгууллагуудад үзүүлэх дэмжлэг:* Хамтарч ажиллах бодлого баримталж, туршлага солилцож байгаа.

*Урамшуулал олгохын урт хугацааны нөлөө:* Эерэг нөлөөтэй

## Дүгнэлт

Мониторингийн объект	Арга барил ба индикатор	Хариуцагчийн санаачлага
<b>Био-физик:</b>	Бэлчээрийн ургамал	Хамгаалж сайжруулах арга хэмжээ авдаг
<b>Техник:</b>	Хашиж хамгаалсан талбай, гүн өрмийн худаг	Засаж сэлбэн, тогтвортой байх нөхцлийг бүрдүүлдэг
<b>Эдийн засгийн/үр ашиг:</b>	Зардал хэмнэдэг, малын зүй бус хорогдлыг багасгадаг	Улирал бүрээр тооцож үздэг
<b>Хамрах талбай:</b>	32 га талбай	Арчилгаа тордолгоог тухай бүрийд хийж гүйцэтгэдэг
<b>Оролцох хүний тоо:</b>	“Олдохын дэвжих хоршоо” нь 18 гишүүнтэй	
<b>Удирдлага зохион байгуулалт:</b>	Олдохын дэвжих хоршооны дарга, гэр бүлийн гишүүд, хоршооны гишүүд	
<b>Давуу тал ба/буюу, хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах</b>	<b>Сул тал ба/буюу, хэрхэн даван туулах</b>	
→ Нөөц бэлчээр бий болгосноор ган, зудны үед мал сүргээ мэнд үлдээх боломжтой	→ Анхлан санаачлан хэрэгжүүлж буй ажил тул мэдлэг, мэдээлэл дутмаг тул хоршооны гишүүдийг сургалтанд хамруулж байх	
→ Хашсан талбайд бэлчээрийн ургамал сайжирснаар элсний нүүлтийг сааруулж хөрсний элэгдлийг бууруулна.	→ Нөөц бэлчээр бий болгосноор гарах ашиг, ач холбогдлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	
→ Тухайн хоршооны өрхүүд ойролцоох аймаг сумын нутгийн газарт нүүдэллэж, бэлчээрт дарамт учруулах шаардлагагүй болно.	→ Анхлан санаачлан хэрэгжүүлж буй ажил тул мэдлэг мэдээлэл дутмаг, хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэл гардаг.	
→ Өндөр хүчдэлийн шугам сүлжээнд холбогдож, гүн өрмийн ундарга сайтай худаг гаргасан тул ирээдүйд эрчимжсэн фермерийн аж ахуй болж хөгжих үндэс суурь нь тавигдсан.		

Тухайн арга барилыг хэрэгжүүлж эрчимжсэн суурин мал маллагааны хэлбэрт шилжсэнээр малчин өрхүүд хөрш зэргэлдээх аймаг сумдын аль ургамлын гарц илүү газрын сонгон нүүдэллэж бэлчээрт дарамт үзүүлдэг мал маллагааны хэлбэрт шинэлэг санааг дэвшүүлж байгаа юм.

**Холбоо барих байгууллага:** ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар  
**Утас:** 976-11-325487 **Факс:** 976-11-322187  
**Вебсайт:** [www.igg.ac.mn](http://www.igg.ac.mn), [www.geo-eco.mn](http://www.geo-eco.mn)